



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 742

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 67,516,680.00 (жаран долоон сая таван зуун арван зургаан мянга зургаан зуун наян) төгрөгийн балансын үнэ, 55,342,155.11 (тавин таван сая гурван зуун дөчин хоёр мянга нэг зуун тавин таван төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132007200

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
710 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	(төгрөг)	
							Дуудлагын худалдаагаар худалдах доод үнэ	
1	УАЗ Парият, 48-49 УНА, 316300B0588345	2011/2011	142111	35,000,000.00	25,608,756.05	9,391,243.95	9,400,000.00	
2	Тэвштэй кран, 27-44 УБТ, FK617J521360	199/2008	777714	32,516,680.00	29,733,399.06	2,783,280.94	3,000,000.00	
НИЙТ ДҮН				67,516,680.00	55,342,155.11	12,174,524.89	12,400,000.00	
				(жаран долоон сая таван зуун арван зургаан мянга зургаан зуун наян)	(тавин таван сая гурван зуун дөчин хоёр мянга нэг зуун тавин таван төгрөг арван нэгэн мөнгө)	(арван хоёр сая нэг зуун далан дөрвөн мянга таван зуун хорин дөрвөн төгрөг наян есөн мөнгө)	(арван хоёр сая дөрвөн зуун мянган)	